



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Мэргэшлийн зэргийн шалгалт зохион
байгуулах эрх олгох тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.13, 25.14 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/513 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ын 3.2.1, 3.2.3, 3.2.5, 3.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэргэшлийн зэргийн шалгалтыг 2023-2025 онд зохион байгуулах мэргэжлийн нийгэмлэг, холбоо, салбар зөвлөлийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан мэргэжлийн нийгэмлэг, холбоо, салбар зөвлөлийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, мэргэшлийн зэргийн гэрчилгээг цахимаар олгож, хүний нөөцийн мэдээний нэгдсэн санд байршуулах ажлыг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.
3. Мэргэшлийн зэргийн шалгалтыг журмын дагуу чанартай зохион байгуулж ажиллахыг эрх олгогдсон мэргэжлийн нийгэмлэг, холбоо, салбар зөвлөлийн тэргүүн, ерөнхийлөгч, дарга нарт үүрэг болгосугай.
4. Мэргэжлийн нийгэмлэг, холбоодын олон улсын нийгэмлэгийн гишүүнчлэлийн хамрагдалт, өөрийн нийгэмлэг, холбооны гишүүнчлэлийн тоог нэмэгдүүлж ажиллахыг тэргүүн, ерөнхийлөгч нарт үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭМНЭЛГИЙН
МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА С.ТӨГСДЭЛГЭР

148222141

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2023 оны ...*04*... дүгээр сарын ...*12*...-ны өдрийн
01... дугаар тогтоолын хавсралт

МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ШАЛГАЛТЫГ 2023-2025 ОНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ МЭРГЭЖЛИЙН НИЙГЭМЛЭГ,
ХОЛБОО, САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НЭРС

№	Мэргэжлийн нийгэмлэг, салбар зөвлөлийн нэр	Мэргэжил, мэргэшлийн чиглэл	Мэргэшлийн зэрэг олгох шатлал
1.	Арьс судлаачдын Монголын нийгэмлэг	Арьс судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
2.	Бие бялдар сэргээн засах судлалын Монголын нийгэмлэг	Сэргээн засал судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
3.	Мэдээгүйжүүлэгч эмч нарын нийгэмлэг	Мэдээгүйжүүлэг судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
4.	Монголын неврологийн нийгэмлэг	Мэдрэл судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Хүүхдийн мэдрэл судлал	Зөвлөх
5.	Монголын нүдний эмч нарын нийгэмлэг	Нүд судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
6.	Монголын радиологийн нийгэмлэг	Дүрс оношилгоо судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Дүрс оношилгооны техникч	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
7.	Монголын сувилагчдын нийгэмлэг	Сувилагч	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Нүүр амны сувилахуй	Зөвлөх
8.	Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг	Сүрьеэ судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
9.	Уламжлалт анагаах ухааны эмч, судлаачдын нийгэмлэг	Уламжлалт анагаах ухааны их эмч	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Зүү эмчилгээ судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
10.	Чих, хамар, хоолойн эмч нарын нийгэмлэг	Чих, хамар, хоолой судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
11.	Эх баригчдын нийгэмлэг	Эх баригч	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
12.	Монголын эрчимт эмчилгээний нийгэмлэг	Эрчимт эмчилгээ судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
13.	Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг	Яаралтай тусламж судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
14.	Монголын гэмтэл согогийн эмч мэргэжилтнүүдийн холбоо	Гэмтэл согог судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
15.	Монголын мэс засалч эмч нарын холбоо	Мэс засал судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх

16.	Монголын халдвартын эмч нарын нийгэмлэг /ДОХ-той тэмцэх нийгэмлэгтэй хамтран зохион байгуулах/	Халдварт өвчин судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		БЗДХ, ХДХВ/ДОХ судлал	Зөвлөх
17.	Халдварт өвчинтэй тэмцэх Монголын үндэсний холбоо	Тархвар судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Зоонозын өвчин судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
18.	Монголын эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын холбоо	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Эмэгтэйчүүдийн аарцгийн хөндий судлал, нөхөн сэргээх мэс засал	Зөвлөх
		Эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, үргүйдэл судлал	Зөвлөх
		Эмэгтэйчүүдийн хавдар судлал	Зөвлөх
		Эх, ураг судлал	Зөвлөх
19.	Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн ЭМ холбоо	Эм зүйч	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Уламжлалт анагаах ухааны эм зүй	Зөвлөх
		Эмийн технологи судлал	Зөвлөх
		Эмийн шинжилгээ судлал	Зөвлөх
		Эмнэл зүйн эм зүй	Зөвлөх
		Эм найруулагч	Ахлах, Тэргүүлэх
20.	Монголын Эрүүл мэндийн лабораторын ажилчдын холбоо	Эмнэл зүйн эмгэг судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Лабораторын техникч	Ахлах, Тэргүүлэх
		Био-анагаах судлаач	Ахлах, Тэргүүлэх
21.	Монголын хүүхдийн анагаахын академи	Хүүхэд судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
22.	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо /Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоотой хамтран зохион байгуулах/	Өрхийн анагаах ухаан судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Хүний их эмч	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Хүний бага эмч	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
23.	Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн холбоо	Нийгмийн эрүүл мэнд судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Биостатистик судлал	Зөвлөх
24.	Монголын шүдний мэргэжилтнүүдийн холбоо	Шүдний ерөнхий эмчилгээ судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх

		Нүүр амны гажиг засал судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Нүүр амны мэс засал судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Нүүр амны согог засал судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Хүүхдийн нүүр ам судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Нүүр амны эрүүл ахуйч	Ахлах, Тэргүүлэх
		Шүдний техникч	Ахлах Тэргүүлэх
25.	Монголын шүүх эмнэлгийн шинжээч эмч нарын нийгэмлэг	Шүүх анагаах ухаан судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
26.	Монголын хавдар судлаач эмч нарын нийгэмлэг /Хавдар судлалын мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулах/	Хавдар судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
27.	Монголын бие бялдар хөдөлгөөн заслын холбоо	Хөдөлгөөн засал судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
28.	Дотрын анагаах судлалын мэргэжлийн салбар зөвлөл	Дотрын анагаах судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
		Бөөр судлал	Зөвлөх
		Дотоод шүүрэл судлал	Зөвлөх
		Зүрх судлал	Зөвлөх
		Ревматологи	Зөвлөх
		Уушиг судлал	Зөвлөх
		Хоол боловсруулах тогтолцоо судлал	Зөвлөх
		Цус судлал	Зөвлөх
29.	Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөл	Анатомийн эмгэг судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
30.	Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөл	Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх
31.	Сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөл	Сэтгэц судлал	Ахлах, Тэргүүлэх, Зөвлөх